

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/128/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых

Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
Байхгүй .....	16
4.3 Албан шаардлага .....	16
4.4 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
7 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.ТОТЫХУС ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠗.17 № 71  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Өлгий-ЕБ-ын-7-dugnelt

Үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Өлгий-ЕБ-ын-7-dugnelt

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>16063833.00</u></b>	<b><u>36455442.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>157406.00</b>	<b>15000000.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	157406.00	15000000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>15906427.00</b>	<b>21455442.00</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7426452.00	7238252.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>8479975.00</b>	<b>14217190.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1114975.00	1168975.00
35470	Бусад хангамжийн материал	7365000.00	13048215.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>472095181.21</u></b>	<b><u>461565997.97</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>472095181.21</b>	<b>461565997.97</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>443367181.21</b>	<b>432837997.97</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	369716240.00	369716240.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29077623.89	-41032318.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103672480.00	108137480.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-73377301.08	-81202199.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37514436.00	41174436.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28013573.62	-30130996.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	256050.00	256050.00
39217	Ном	62676473.80	65919306.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>28728000.00</b>	<b>28728000.00</b>
39301	Програм хангамж	560000.00	560000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-560000.00	-560000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28728000.00	28728000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>488159014.21</u></b>	<b><u>498021439.97</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>488159014.21</u></b>	<b><u>498021439.97</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>488159014.21</b>	<b>498021439.97</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>124480113.80</b>	<b>124480113.80</b>
51101	Өмч: - төрийн	124480113.80	124480113.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>187623358.48</b>	<b>197485784.24</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	187623358.48	187623358.48
51220	Тайлант үеийн үр дүн		9862425.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176055541.93	176055541.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>488159014.21</u></b>	<b><u>498021439.97</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>791268621.00</b>	<b>828471172.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>582435.00</b>	<b>1622730.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	582,435.00	1,622,730.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>744985486.00</b>	<b>782979733.00</b>
131005	Хөрөнгийн санхүүжилт	17658086.00	3242833.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	727327400.00	779736900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>10715409.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10715409.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45700700.00</b>	<b>33153300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45700700.00	33153300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>793838950.54</b>	<b>818608746.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>793838950.54</b>	<b>818608746.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>779293229.54</b>	<b>770672346.24</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>619523375.00</b>	<b>618580627.00</b>
210101	Үндсэн цалин	542218198.00	551719669.00
210104	Урамшуулал	54505728.00	43372968.00
210105	Гэрээт ажлын хөлс	22799449.00	23487990.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78935278.00</b>	<b>82000179.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	53711185.00	56767015.00
210202	Тэтгэмжийн даатгал	6318962.00	6308351.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3256565.00	5046681.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3062394.00	1261467.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12586172.00	12616665.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39895020.00</b>	<b>32313500.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1125820.00	1285360.00
210302	Түлш, халаалт	38769200.00	31028140.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4503460.00</b>	<b>5902200.00</b>
210401	Бичиг хэрэг	632600.00	1133900.00
210402	Тээвэр, шатахуун		445000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1192500.00	867800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2678360.00	3455500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>772500.00</b>	<b>1649615.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	135000.00	1649615.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	637500.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>839800.00</b>
210604	Урсгал засвар		839800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>457500.00</b>	<b>1020500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20000.00	583000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	437500.00	437500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35206096.54</b>	<b>28365925.24</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4850800.00	6468909.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30355296.54	21897016.24

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14545721.00</b>	<b>47936400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14542341.00</b>	<b>47936400.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	65841.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14476500.00	47936400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3380.00</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3380.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-2570329.54</b>	<b>9862425.76</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-2570329.54</b>	<b>9862425.76</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0	0.00
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,480,113.80	176,055,541.93	187,623,358.48	0	488,159,014.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,480,113.80	176,055,541.93	187,623,358.48	0	488,159,014.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			9,862,425.76		9,862,425.76
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,480,113.80	176,055,541.93	197,485,784.24	0	498,021,439.97

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>773028100.00</b>	<b>823605609.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>727327400.00</b>	<b>779736900.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	727327400.00	779736900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>10715409.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10715409.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45700700.00</b>	<b>33153300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45700700.00	33153300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>763556100.00</b>	<b>815480609.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>763556100.00</b>	<b>815480609.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>745908520.00</b>	<b>767544209.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>618109700.00</b>	<b>617113100.00</b>
210101	Үндсэн цалин	530438300.00	552459400.00
210104	Урамшуулал	69520200.00	41964800.00
210105	Гэрээт ажлын хөлс	18151200.00	22688900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>80582300.00</b>	<b>83310300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	56727600.00	58625800.00
210202	Тэтгэмжийн даатгал	5971500.00	6171100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4747000.00	4936900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1193500.00	1234200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11942700.00	12342300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36357320.00</b>	<b>32313500.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2455820.00	2459200.00
210302	Түлш, халаалт	33901500.00	20770000.00
210303	Цэвэр, бохир ус		9084300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5653600.00</b>	<b>6564100.00</b>
210401	Бичиг хэрэг	806400.00	252200.00
210402	Тээвэр, шатахуун	1640000.00	1550000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	927000.00	1093000.00
210404	Ном, хэвлэл	417600.00	576300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1862600.00	3092600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1788100.00</b>	<b>1504900.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111900.00	784500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1676200.00	720400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>15839800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		15000000.00
210604	Урсгал засвар		839800.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>230000.00</b>
210702	Дотоод албан томиллолт		230000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>437500.00</b>	<b>760200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		360200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	437500.00	400000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2980000.00</b>	<b>9908309.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2980000.00	9908309.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17647580.00</b>	<b>47936400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17644200.00	47936400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3380.00</b>	<b>0.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3380.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>9472000.00</b>	<b>8125000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9472000.00</b>	<b>8125000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9472000.00</b>	<b>8125000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9472000.00	8125000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-9472000.00</b>	<b>-8125000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>812890200.00</b>	<b>812890200.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>812890200.00</b>	<b>812890200.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>764953800.00</b>	<b>764953800.00</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>617113100.00</b>	<b>617113100.00</b>
Үндсэн цалин	552459400.00	552459400.00
Урамшуулал	41964800.00	41964800.00
Гэрээт ажлын хөлс	22688900.00	22688900.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83310300.00</b>	<b>83310300.00</b>
Тэтгэврийн даатгал	58625800.00	58625800.00
Тэтгэмжийн даатгал	6171100.00	6171100.00
ҮОМШӨ-ний даатгал	4936900.00	4936900.00
Ажилгүйдлийн даатгал	1234200.00	1234200.00
Эрүүл мэндийн даатгал	12342300.00	12342300.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32313500.00</b>	<b>32313500.00</b>
Гэрэл, цахилгаан	2459200.00	2459200.00
Түлш, халаалт	20770000.00	20770000.00

Цэвэр, бохир ус	9084300.00	9084300.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6064100.00</b>	<b>6064100.00</b>
Бичиг хэрэг	252200.00	252200.00
Тээвэр, шатахуун	1050000.00	1050000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1093000.00	1093000.00
Ном, хэвлэл	576300.00	576300.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3092600.00	3092600.00
<b>Нормативт зардал</b>	<b>1324900.00</b>	<b>1324900.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	604500.00	604500.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	720400.00	720400.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18839800.00</b>	<b>18839800.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	18000000.00	18000000.00
Урсгал засвар	839800.00	839800.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>230000.00</b>	<b>230000.00</b>
Дотоод албан томилолт	230000.00	230000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>760200.00</b>	<b>760200.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360200.00	360200.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000.00	400000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4997900.00</b>	<b>4997900.00</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4997900.00	4997900.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47936400.00</b>	<b>47936400.00</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47936400.00	47936400.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>812890200.00</b>	<b>812890200.00</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>779736900.00</b>	<b>779736900.00</b>
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	779736900.00	779736900.00
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>33153300.00</b>	<b>33153300.00</b>
Орон нутгийн төсвөөс	33153300.00	33153300.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
Төсвийн байгууллага	1	1
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>55</b>	<b>54</b>
Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	32	30
Үйлчлэх ажилтан	17	17
Гэрээт ажилтан	5	6
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>55</b>	<b>54</b>
Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1
СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	32	30
Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	17
Гэрээт ажилтан	5	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>10715409.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>10715409.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	10715409.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>500000.00</b>
210402	Тээвэр, шатахуун		500000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>180000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		180000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>10035409.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10035409.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>10715409.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>10715409.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10715409.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)-(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ужиг алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус

сургууль нь 2021 оны хичээлийн жилд "Халдвар хамгааллын дэглэмээ сахиж сургалтын чанарыг сайжруулан зөв чийрэг хэвшилтэй, эрүүл биетэй сурагчийг төлөвшүүлнэ" гэсэн зорилготой ажиллаж, дараах үндсэн 5 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Цахим хичээлийн сан болон идэвхтэй суралцах шинэ аргуудаас судалж хичээл сургалтад байнга ашиглах.
2. Сурлагын хоцрогдлыг арилгах тусгай төлөвлөгөөний дагуу сургалтын чанарт ахиц гаргах.
3. Сурагчийн бие даан ажиллах үйлийг дэмжсэн дасгал, даалгаврын сан боловсруулан ажиллах.
4. Суралцагчдын унших чадварт онцгойлон анхааран ажиллах.
5. Багш нараа ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжоор хангах дэмжин туслах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Ерөнхий боловсролын 7 дугаар сургуульд 2021 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019, 2020 оны материалд шалгалт хийгдсэн. Аймгийн засаг даргын захирамжаар Боловсрол соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Санхүүгийн хяналт аудитын албаны хамтарсан шалгалт хийгдсэн байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитаас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 793.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.9 сая төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	157.4	15000.0	14842.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	15906.4	21455.4	5549.0
Үндсэн хөрөнгө	472095.2	461566.0	-10529.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>488159.0</b>	<b>498021.4</b>	<b>9862.4</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	488159.0	498021.4	9862.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>488159.0</b>	<b>498021.4</b>	<b>9862.4</b>

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 15.0 сая төгрөгөөр өссөн нь Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу Багшийн хөгжлийн танхим ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг “Чарж” ХХК-ний дансанд хөрөнгө нийлүүлэхээр шилжүүлж, шинээр авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 21.5 сая төгрөг болж 5.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 16.1 сая төгрөгийн материал худалдан авч, 1.6 сая төгрөгийн материалыг үнэгүй хүлээн авсан 12.1 сая төгрөгийн материал зарцуулж, бусад хангамж материал дансны үлдэгдэл 4.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 461.5 сая төгрөг болж 10.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 8.1 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 3.2 сая буюу нийт 11.4 сая төгрөгөөр нэмэгдсэн ба хөрөнгөнд 21.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 498.0 сая төгрөг болж 9.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 9.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 828.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 37.2 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй бараа материал авсан, тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилт авсантай холбоотой нэмэлт санхүүжилтийн орлого материаллаг хэмжээний өөрчлөлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 24.8 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусад урсгал шилжүүлгээс төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал буюу үдийн цайны зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2020 оны анх батлагдсан төсөв 744.2 сая төгрөг, тодотгосон төсөв 812.9 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 68.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 66.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 9.0 сая төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 2.2 сая төгрөгөөр, эм бэлдмэлийн зардал 0.5 сая төгрөгөөр, багаж техник, хэрэгсэл 18.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, цэвэр бохир усны зардал 2.0 сая төгрөгөөр, дотоод албан томилолт 0.06 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 27.7 сая төгрөгөөр анх баталснаас хасаж тодотгол хийгдсэн байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 75.8 сая төгрөгөөр дутуу суулгасан, нэмэгдэл, урамшлын зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль нь тайлант онд 812.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 812.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 812.9 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 75.9 хувийг цалин, 10.2 хувийг НДШ-ийн зардал, 4.0 хувийг тогтмол зардал, 0.7 хувийг хангамж бараа материалын зардал, 0.16 хувийг норматив зардал, 2.3 хувийг урсгал засварын зардал, 0.02 хувийг томилолт, зочны зардал, 0.09 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 5.9 хувийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 10.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна. Үүнээс хангамж бараа материалын зардалд 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 10.0 сая, эмийн зардалд 0.18 сая, нийт 10.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 617.1 сая төгрөг, НДШ-ийн зардалд 83.3 сая төгрөг, халаалтын зардалд 32.3 сая төгрөг, урсгал засвар, эмийн зардалд 19.4 сая төгрөг, үдийн цайны зардалд 47.9 сая төгрөг нийтдээ 800.0 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 812.9 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 800.0 сая төгрөгийг хасахад 12.9 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 1.3 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс хэмнэлт гаргаж ажиллаагүй тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу Багшийн хөгжлийн танхим ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг сургуулийн захирал “Чарж” ХХК-тай тоног төхөөрөмж нийлүүлэх 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдөр №12 тоот ажлын гэрээ хийж, тус компанийн Голомт банкны 1415141092 дансанд шилжүүлэн шинээр авлага үүсгэсэн байна. Гэрээнд тоног төхөөрөмжийг 2022 оны 2 дугаар сарын 10-ны дотор нийлүүлэхээр заасан боловч хүлээж аваагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль нь 2021 онд нийт 812.9 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 812.9 төгрөгийн 136 мэдээллийг хугацаандаа байршуулж, 13 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 2 мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд төсвөөс зарцуулагдаагүй 0.015 сая төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр татварын тооцоонд шилжүүлж авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага, шилэн дансны 34 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд авлагыг барагдуулж, зөвлөмжийн хэрэгжүүлэн өмнөх оны зөрчлийг давтан гаргаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар 1.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль 2021 онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1.3 сая төгрөгийг хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль	1	1.3					1	1.3		